



МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН ЭВЛЭЛИЙН ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл.

Нэгдүгээр зүйл. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү дүрмийн зорилт нь Монголын Архитекторуудын Эвлэл (цаашид "МАЭ" гэх)-ийн Монголын архитектурыг хөгжүүлэх, гишүүдийнхээ хууль ёсны эрхийг хамгаалах, гишүүдээ дэмжих, Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд өөрийгөө удирдах зарчмаар байнгын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор гишүүдийн эрх үүрэг, удирдлагын эрх зүйн байдал, байгууллагын үйл ажиллагааны хэм хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. МАЭ нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль, дүрэм, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенци болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм журам, Архитекторуудын ёс зүйн Монгол Улсын Стандарт MNS, Олон Улсын Архитекторуудын Эвлэлээс баталж гаргасан "Архитекторын зөвлөх үйлчилгээний ёс зүйн дүрэм" болон энэ дүрмийг удирдлага болгон ажиллах гишүүнчлэлтэй, нийгэмд болон гишүүдээ үйлчилдэг мэргэжлийн төрийн бус байгууллага мөн.
- 1.3. МАЭ-ийн оноосон нэр:
 - 1.3.1 Монгол хэлээр: МОНГОЛЫН АРХИТЕКТОРУУДЫН ЭВЛЭЛ (товчилбол МАЭ)
 - 1.3.2 Англи хэлээр: THE UNION OF MONGOLIAN ARCHITECTS (товчилбол UMA)
- 1.4. МАЭ-ийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Болгарын гудамж - 27, МАЭ-ийн ордон. (Архитектор Б.Чимэдийн гудамжны зүүн тал)
- 1.5. МАЭ-ийг үүсгэн байгуулсан огноо: 1956 оны 10 дугаар сарын 23-ны өдөр.
- 1.6. МАЭ нь аймаг, хотод салбаруудтай, дэргэдээ зөвлөлүүдтэй байна.
- 1.7. МАЭ нь бэлэг тэмдэг /лого/, туг, данс, албан бичгийн хуудас, хэвлэл, вэб хуудас, хүндэт дэвтэр, шагналтай байна.

Хоёрдугаар зүйл. МАЭ-ийн эрхэм зорилго, үнэт зүйл.

- 2.1 МАЭ-ийн эрхэм зорилго нь: Монголын архитектур, хот байгуулалтыг хөгжүүлэх, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн гишүүдийнхээ мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, МАЭ-ийн үйл ажиллагааг Олон Улсын архитекторуудын байгууллагын жишигт нийцүүлэн ажиллана.
- 2.2 МАЭ-ийн үнэт зүйл нь: Монголын архитектурын түүх, МАЭ-ийн түүх, гишүүд, оюуны өмч, архитектурын дурсгал өв соёл, үзэл баримтлал, хөгжлийн хэтийн бодлого, гишүүдийн оролцоотой бүтээн байгуулагдсан эд хөрөнгө мөн.

Гуравдугаар зүйл. МАЭ-ийн үйл ажиллагааны чиглэл, зарчим

3.1 Үндсэн чиглэл

- 3.1.1 МАЭ-ийн дүрмийг хэрэгжүүлэх, гишүүдийн эрх агшийг хамгаалах, мэдээллээр хангах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
- 3.1.2 Монголын архитектурын салбарыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг

- боловсруулахад оролцох, төрийн үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
- 3.1.3 Архитектур хот төлөвлөлтийн мэргэжлийн зөвлөлийг ажиллуулж, зөвлөмж гарган төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,
 - 3.1.4 Монголын архитектурыг олон нийт, дэлхий дахинд сурталчлан таниулах, монголын архитектурын бүтээлийг нийтийн хүртээл болгох,
 - 3.1.5 Олон улсын архитектурын сургалтын хөтөлбөрийн агуулгыг архитектурын их дээд сургуулиудын сургалтанд нэвтрүүлэх,
 - 3.1.6 Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж, архитекторуудын лицензийн болон мэргэшсэн, зөвлөх зэрэг олгох иж бүрэн сургалтыг олон улсын стандартаар зохион байгуулах,
 - 3.1.7 Архитектурын судалгаа, шүүмж, эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх, чадварлаг өндөр түвшний архитекторуудыг төлөвшүүлэх,
 - 3.1.8 Дүрмийг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа явуулах,
 - 3.1.9 Нийт иргэдийн архитектурын талаархи мэдлэг гоо зүйн соёлыг дээшлүүлэх, нийгэмд үйлчлэх хүрээг өргөжүүлэх,
 - 3.1.10 Гадаад харилцааг хөгжүүлэх, архитекторуудаа олон улсад дадлагажуулах, хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагааг идэвхитэй явуулах,
 - 3.1.11 МАЭ-нь гадаад, дотоодын иргэн, хуулийн итгээдтэй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бие даасан бодлоготой, харилцан тэгш эрхтэйгээр хамтарч ажиллана.

3.2 Баримтлах зарчим.

- 3.2.1 Монгол Улсын Үндсэн хууль бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд МАЭ-ийн хэтийн хөгжлийн бодлого, эрхэм зорилго үзэл баримтлалыг эрхэмлэн дээдэлж, ардчилсан шударга зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хараат бус, бие даасан, хариуцлагатай үйл ажиллагаа явуулна.
- 3.2.2 МАЭ-нь өөрийгөө удирдаж санхүүжүүлнэ.
- 3.2.3 Аливаа бодлого шийдвэр, үйл ажиллагаа нь гишүүдэд ил тод нээлттэй байна.
- 3.2.4 МАЭ-ийн гишүүд, ажилтан, сонгуультнууд эв санааны нэгдэл, ёс зүй, байгууллагын нэр хүндийг эрхэмлэн дээдэлж хамтран ажиллана.
- 3.2.5 Шийдвэр гаргах үйл ажиллагааг хамтын зарчимд тулгуурлан явуулна.

3.3 Хориглох зүйл

- 3.3.1 МАЭ-ийн салбар, зөвлөлүүд дүрмийн бус, бие даасан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 3.3.2 МАЭ-ийн сонгуульт болон удирдах, томилогдох ажилтанд дор дурьдсан үндэслэлээр нэрийг дэвшүүлэн сонгох, томилохыг хориглоно.
 - 3.3.2.1 МАЭ-ийн нэр хүндэд болон санхүүгийн хохирол учруулсан,
 - 3.3.2.2 Ямар нэг байгууллагад өртэй, төлбөртэй,
 - 3.3.2.3 МАЭ-ийн гишүүний үүргээ биелүүлээгүй,

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дөрөвдүгээр зүйл. МАЭ-ийн бүтэц

- 4.1 МАЭ-ийн удирдлагын дээд байгууллага нь бүх гишүүдийн төлөөлөл бүхий их хурал байна.
- 4.2 МАЭ-ийн ээлжит Их хурал нь 3 жилд нэг удаа хуралдана. Ээлжит бус их хурлыг тодорхой зорилтыг хэрэгжүүлэх болон дүрмийн холбогдох шаардлагын дагуу бүх гишүүдийн 75-ээс дээш хувийн шаардлагаар хуралдуулж болно.
- 4.3 Их хурлын чөлөөт хугацаанд МАЭ-ийн үйл ажиллагааг Ерөнхийлөгч, их хурлаас сонгогдсон удирдах зөвлөл удирдан зохион байгуулна.

Тавдугаар зүйл. МАЭ-ийн Их хурал

- 5.1 МАЭ-ийн ээлжит их хурлыг Их хурлаас томилогдсон дарга, тэргүүлэгчид удирдан явуулна.

- 5.2 Их хурлын мандаттай төлөөлөгчдийн 2/3 хувь нь хүрэлцэн ирснээр Их хурал хүчинтэй болно.
- 5.3 Их хурлаар хэлэлцэж буй асуудлыг мандаттай төлөөлөгчдийн 50+1 ээс дээш хувийн саналаар батлана.
- 5.4 Их хурал хуралдуулах товыг хурал болохоос 21 хоногийн өмнө бүх гишүүдэд хүргэж, их хуралд бэлтгэх ажлын хэсэг байгуулан бэлтгэнэ.
- 5.5 Их хурлын төлөөлөгч өөрийн биеэр хуралдаанд оролцох боломжгүй бол энэ тухай хурал эхлэхээс 3 хоногийн өмнө хурал зохион байгуулагчид мэдэгдэн, хурлаар хэлэлцэх асуудлаар саналаа урьдчилан бичгээр өгч болно.
- 5.6 Их хурлаар дор дурьдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргана.
 - 5.6.1 МАЭ-ийн үйл ажиллагааны болон Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэх,
 - 5.6.2 МАЭ-ийн дүрмийг батлах, өөрчлөлт оруулах, гишүүний татварын хэмжээг тогтоох
 - 5.6.3 Монголын архитектур, хот байгуулалтын хөгжлийн бодлого, архитектурын урт хугацааны хөтөлбөрийг хэлэлцэх, батлах
 - 5.6.4 МАЭ-ийн Ерөнхийлөгчийг сонгож, батлах,
Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг Их хурлын төлөөлөгчдийн нууц санал хураалтаар, саналын мандаттай төлөөлөгчдийн 50+1, түүнээс дээш хувийн саналаар сонгоно.
 - 5.6.5 МАЭ-ийн Удирдах зөвлөлийг 15 гишүүний бүрэлдэхүүнтэй, хяналтын зөвлөлийг 3 гишүүний, ёс зүйн хороог 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ил санал хураалтаар сонгох,
 - 5.6.6 МАЭ-ийн үнэт зүйл, үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг хэлэлцэх,
 - 5.6.7 Их хурлаас сонгогдсон ерөнхийлөгч дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж нийт гишүүдийн 75 хувь үзвэл ээлжит бус их хурлыг дүрмийн дагуу хуралдуулж хугацаанаас нь өмнө чөлөөлөх,
 - 5.6.8 МАЭ-ийг өөрчлөх, татан буулгах,

Зургадугаар зүйл. МАЭ-ийн Удирдах зөвлөл

- 6.1 МАЭ-ийн Их хурлын хурлын чөлөөт цагт эрх барих байгууллага нь Их хурлаас сонгогдсон Удирдах зөвлөл байна.
- 6.2 Удирдах зөвлөлийн дарга нь МАЭ-ийн Ерөнхийлөгч байх бөгөөд бусад гишүүдтэй ижил саналын эрхтэй байна.
- 6.3 Удирдах зөвлөлийн гишүүн нь сүүлийн 4 өөс доошгүй жил тасралтгүй гишүүнчлэлтэй байгаа, МАЭ-ийн ажилд тогтмол оролцдог, дүрэмд заасан үүргийг биелүүлдэг, багаар ажиллах чадвартай хамт олны итгэлийг хүлээсэн гишүүн байна.
- 6.4 Удирдах зөвлөлийн гишүүн нь тусгайлсан цалин хангамжгүй байна.
- 6.5 Удирдах зөвлөл доорхи эрх үүргийг хэрэгжүүлнэ.
 - 6.5.1 МАЭ-ийн ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг хэлэлцэн батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
 - 6.5.2 Их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, шаардлагатай дүрэм, журмыг боловсруулан батлах, хэрэгжилтэнд хяналт тавих,
 - 6.5.3 МАЭ-ийн ажлын албны бүтэц зохион байгуулалт, орон тоо, төсөв ажил үүргийг хэлэлцэн батлах, хяналт тавих,
 - 6.5.4 МАЭ-ийн томилогдох албан тушаалтныг нээлттэй ажлын байрны сонгон шалгаруулалтыг үндэслэн томилох, чөлөөлөх,
 - 6.5.5 МАЭ-ийн гишүүн элсүүлэх, хасах, дүрэм журмыг батлах, хэрэгжүүлэх,
 - 6.5.6 Гишүүдийг шагнал урамшуулалд тодорхойлох, шагнах,
 - 6.5.7 Үйл ажиллагааны чиглэл хариуцсан дэд ерөнхийлөгч болон салбаруудыг байгуулах, томилох, чөлөөлөх,
 - 6.5.8 Удирдах зөвлөлийн хурлыг сар тутамд хийж холбогдох шийдвэрийг гаргана.
 - 6.5.9 Удирдах зөвлөлийн хуралд МАЭ-ийн Ерөнхийлөгч оролцоогүй тохиолдолд насаар хамгийн ахмад гишүүн хурлыг удирдах,
 - 6.5.10 Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар тэмдэглэл

- хөтлөн, тогтоол гаргаж, Ерөнхийлөгч гарын үсэг зурж баталгаажуулах,
- 6.5.11 Удирдах зөвлөлийн гишүүн нь МАЭ-ийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба холбогдох зөвшөөрөлгүйгээр МАЭ-ийг төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах, цуцлах, МАЭ-ийн өдөр тутмын болон санхүүгийн үйл ажиллагаанд оролцох эрхгүй байх,
- 6.5.12 Удирдах зөвлөлийн гишүүн нь МАЭ-ийн үйл ажиллагааны хүрээнд гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнгээр урамшуулал авч болох,
- 6.6 Удирдах зөвлөлийн гишүүнийг дор дурьдсан үндэслэлээр сонгуульт ажлаас чөлөөлнө.
- 6.6.1 МАЭ-ийн дүрмийн заалтыг ноцтой буюу давтан зөрчсөн, хөдөлмөрийн чадвараа алдсан, хуралдаанд хүндэтгэх шалтгаангүй 4-өөс дээш удаа оролцоогүй, ёс зүйн алдаа гаргасан, өөрөө өргөдөл хүсэлт гаргасан бол,
- 6.6.2 Удирдах зөвлөлийн гишүүнийг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж олонхын саналаар сонгуульт ажлаас чөлөөлнө.

МАЭ-ийн Ерөнхийлөгч

- 6.8 МАЭ-ийн Ерөнхийлөгч нь МАЭ-ийн Удирдах дээд албан тушаалтан мөн.
- 6.9 МАЭ-ийн Ерөнхийлөгч нь архитектор мэргэжилтэй, Зөвлөх архитекторын зэрэгтэй, МАЭ-ийн Удирдах зөвлөлд ажиллаж байсан, удирдах албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан, салбарын болон бусад төрийн бус байгууллагын удирдлага, удирдах зөвлөлд ажиллаагүй, ёс зүйн алдаа гаргаагүй, нэр дэвшүүлэх "Нийтлэг журам"-ын шаардлага хангасан гишүүн байна.
- 6.10 Ерөнхийлөгч нь дор дурьдсан эрх үүргийг хэрэгжүүлнэ.
- 6.10.1 Архитектурын боловсролыг, архитекторуудын болон архитектур хот байгуулалтын мэргэжлийн үйл ажиллагааг дэмжих, МАЭ-ийн үнэт зүйл, эд хөрөнгө, санхүүг бэхжүүлэх,
- 6.10.2 МАЭ-ийн ерөнхийлөгч нь Удирдах зөвлөлийн дарга байх бөгөөд хуралдааныг удирдах, удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтийг хянах ажлыг зохион байгуулна.
- 6.10.3 МАЭ-ийн гишүүний үнэмлэхийг гарын үсэг зурж баталгаажуулах,
- 6.10.4 МАЭ-ийг гадаад дотоодод төлөөлөх, томилогдох албан тушаалтан, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах,
- 6.10.5 МАЭ-ийн Ерөнхийлөгч МАЭ-ийн тамгыг хариуцаж 1-р гарын үсэг зурах эрхтэй байна. Тамгыг бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 6.10.6 Удирдах зөвлөлийн гишүүн хууль, дүрэм зөрчсөн, хариуцлага алдсанаас хохирол үүссэн, шаардлагатай гэж үзвэл УЗ-ийн гишүүдийн 30 хүртэлх хувийг хугацаанаас нь өмнө өөрчлөх асуудлыг шийдвэрлэх,
- 6.11 МАЭ-ийн Ерөнхийлөгч МАЭ-ийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд Удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр гадны байгууллагатай гэрээ хэлцэл байгуулах, цуцлах эрхгүй.
- 6.12 Ерөнхийлөгчийг МАЭ-ийн нэр, хуулийн этгээдийн эрх, албан тушаалаа хувийн эрх ашгийн төлөө ашиглахыг хориглоно.
- 6.13 Ерөнхийлөгчийн сонгуульт хугацаа нь дуусгавар болж буй ерөнхийлөгч нь дахин нэр дэвших, улиран сонгогдох эрхтэй.
- 6.10 МАЭ-ийн үйл ажиллагааны залгамж халааг үргэлжлүүлэх зорилгоор сонгуульт хугацаа нь дууссан ерөнхийлөгч нь нэг сонгуулийн хугацаанд МАЭ-ийн Зөвлөхөөр ажиллана.
- 6.11 Ерөнхийлөгч нь сонгуульт ажлын тогтмол цалинтай байх ба Удирдах зөвлөлөөс цалингийн хэмжээг тогтооно.

МАЭ-ийн дэд ерөнхийлөгч

- 6.12 МАЭ нь үйл ажиллагаа чиглэлээс хамаарч 3 хүртэлх дэд ерөнхийлөгчтэй байх,
- 6.13 Дэд ерөнхийлөгчид нь орон тооны бус байх ба ерөнхийлөгчөөс дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч МАЭ-ийн гишүүнийг удирдах зөвлөлд санал болгож хэлэлцүүлэн томилох, чөлөөлөх.
- 6.13.1 МАЭ-ийн ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр дэд ерөнхийлөгч нь чиглэл хариуцан үүрэг хүлээж ажиллана.

МАЭ-ийн Хүндэт ерөнхийлөгч

- 6.14 Архитектурын боловсролыг дэмжсэн, архитекторуудын эн тэргүүнд гүйцэтгэх үүргийг

дээшлүүлэх, архитектур хот байгуулалтын мэргэжлийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан, МАЭ-ийн үнэт зүйл, эд хөрөнгө, санхүүг бэхжүүлэх талд онцгой амжилт гаргасан, сонгуулийн хугацаа нь дуусгавар болсон зарим нэг ерөнхийлөгчийг "Хүндэт ерөнхийлөгч"-өөр өргөмжилж болно.

6.14.1 Хүндэт ерөнхийлөгчийг МАЭ-ийн Их хурлаар баталгаажуулж, батламж, тэмдэг олгоно.

6.14.2 МАЭ-ийн "хүндэт ерөнхийлөгч" нь эвлэлийг төлөөлөх эрхгүй.

МАЭ-ийн Хяналтын зөвлөл

6.15 МАЭ- нь 3 хүний бүрэлдэхүүнтэй Хяналтын зөвлөлтэй байна.

6.16 Хяналтын зөвлөл нь дараахь эрх үүргийг хэрэгжүүлнэ.

6.16.1 МАЭ-ийн дүрмийн хэрэгжилт, Их хурал болон Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих,

6.16.2 МАЭ-ийн санхүүжилт, батлагдсан төсвийн зарцуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих,

6.16.3 МАЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх байгууллагыг сонгон шалгаруулж, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

6.17 Хяналтын зөвлөл нь аливаа асуудлыг зөвхөн Хяналтын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.18 Хяналтын зөвлөл нь жилд 2 удаа хуралдах ба ажлын тайлангаа 3 жилд 1 удаа Их хуралд тайлагнана.

6.19 Хяналтын зөвлөл нь МАЭ-ийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой мэдээ баримтыг саадгүй гаргуулан авах эрхтэй.

6.20 Хяналтын зөвлөлийн гишүүн нь МАЭ-ийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд хяналтын зөвлөлийн шийдвэргүйгээр бие даасан үйл ажиллагаа явуулах эрхгүй.

6.21 Хяналтын зөвлөлийн гишүүнийг дор дурьдсанаас бусад асуудлаар сонгуульт ажлаас чөлөөлж үл болно.

6.21.1 МАЭ-ийн дүрмийн заалтыг ноцтой буюу давтан зөрчсөн, хөдөлмөрийн чадвараа алдсан, хуралдаанд хүндэтгэх шалтгаангүй 3-өөс дээш удаа оролцоогүй, ёс зүйн алдаа гаргасан, өөрөө өргөдөл хүсэлт гаргасан,

6.21.2 Хяналтын зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх, нөхөн сонгох асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх,

6.22 Хяналтын зөвлөлийн гишүүн нь Хяналтын зөвлөлийн гишүүний цалин урамшуулал авахгүй бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд гаргасан зардлаа буцаан авч болно.

Ёс зүйн хороо

6.23 Ёс зүйн хороо нь МАЭ-ийн дүрэм, Архитекторуудын ёс зүйн болон улсын дүрэм-ийн шаардлагыг хангуулах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах, дүрэм зөрчсөн гишүүдийн асуудлыг шийдвэрлэх, архитекторуудын үйл ажиллагааны талаархи захиалагч, иргэд, хуулийн байгууллагаас гаргасан гомдол, маргааныг барагдуулах үүрэгтэй.

6.24 Ёс зүйн хорооны 5 гишүүнийг Их хурлаас сонгож батлах ба батлагдсан дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, Их хуралд тайлагнана.

6.25 Ёс зүйн хорооны гишүүнийг дор дурьдсанаас бусад асуудлаар сонгуульт ажлаас чөлөөлж үл болно.

6.25.1 МАЭ-ийн дүрмийн заалтыг ноцтой буюу давтан зөрчсөн, хөдөлмөрийн чадвараа алдсан, хуралдаанд хүндэтгэх шалтгаангүй 3-өөс дээш удаа оролцоогүй, ёс зүйн алдаа гаргасан, өөрөө өргөдөл хүсэлт гаргасан,

6.25.2 Ёс зүйн хорооны гишүүнийг чөлөөлөх, нөхөн сонгох асуудлыг Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх,

6.26 Ёс зүйн хорооны гишүүн нь Ёс зүйн хорооны гишүүний цалин урамшуулал авахгүй бөгөөд тухайн ажил гүйцэтгэхэд гаргасан зардлаа буцаан авч болно.

Долдугаар зүйл. Гүйцэтгэх захирал, томилогдох ажилтнууд

- 7.1 МАЭ-ийн Удирдах зөвлөлийн шийдвэрээр гүйцэтгэх захирлыг томилно.
- 7.2 Гүйцэтгэх захирал нь МАЭ-ийн гишүүн байх бөгөөд ажил зохион байгуулах, багаар ажиллах чадвартай, санхүүгийн зохих мэдлэгтэй байна.
- 7.3 МАЭ-ийн гүйцэтгэх захирал нь хувийн ашиг сонирхлыг эрхэмлэсэн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 7.4 МАЭ-ийн гүйцэтгэх захирал нь дараах эрх үүрэгтэй.
 - 7.4.1 Гүйцэтгэх захирал нь МАЭ-ийн ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр үүрэг хүлээж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,
 - 7.4.2 Удирдах зөвлөлийн хурлаар баталсан төсөв, тогтоосон хэмжээний хүрээнд өмч хөрөнгийг захиран зарцуулах, удирдах зөвлөлд тайлагнах,
 - 7.4.3 Гүйцэтгэх захирал нь Удирдах зөвлөлийн хуралд ажлын болон санхүүгийн тайланг сар бүр ирүүлж, тайлагнах,
- 7.5 Томилогдох ажилтан албан тушаалтнуудыг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж томилоно.
 - 7.5.1 Гүйцэтгэх захирал,
 - 7.5.2 Санхүүгийн ажилтан, нягтлан бодогч, үйлчилгээний ажилтан,
 - 7.5.3 Сургалтын болон ажлын албаны дарга, менежер
 - 7.5.4 Монголын архитектур сэтгүүлийн редакци, сэтгүүлч
 - 7.5.5 Орон тооны бус дэд ерөнхийлөгчид,
 - 7.5.6 Салбар, зөвлөлийн дарга,

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Наймдугаар зүйл. МАЭ-ийн гишүүнчлэл

- 8.1 МАЭ-ийн зорилго, дүрэм, журам, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч, гишүүн болох хүсэлтэй архитектор мэргэжилтэй Монгол Улсын иргэний өргөдлийг МАЭ-ийн ажлын алба хүлээн авч, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн гишүүнчлэлийг шийдвэрлэнэ.
- 8.2 Монгол Улсад архитектур, хот төлөвлөлтийн мэргэжлийн үйл ажиллагааг 5-аас дээш жил эрхэлж буй гадаадын иргэн архитектор, байгууллага МАЭ-ийн гишүүн, гишүүн байгууллагад элсч болно.
- 8.3 МАЭ-ийн гишүүн нь гишүүний үнэмлэх, тэмдэгтэй байна.
- 8.4 **МАЭ-ийн гишүүний эрх**
 - 8.4.1 МАЭ-ийн гишүүн нь дор дурьдсан эрхтэй байна.
 - 8.4.1.1 Гишүүн нь МАЭ-ийн үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох,
 - 8.4.1.2 МАЭ-ийн албан тушаалд сонгогдох, томилогдох,
 - 8.4.1.3 МАЭ-ийн үйл ажиллагааны талаар санал бодлоо зохих журмын дагуу илэрхийлэх, шийдвэрлүүлэх,
 - 8.4.1.4 Гишүүний оролцоо, мэргэжлийн ур чадвараа үнэлүүлэх, тодорхойлолт гаргуулах,
 - 8.4.1.5 МАЭ-ийн зохион байгуулсан сургалт, хурал зөвлөгөөн, гадаад дотоод арга хэмжээ, үзэсгэлэнд оролцож бүтээлээ сурталчлах, МА сэтгүүлээр сурталчлуулах, шагнал урамшуулал авах, шагналд тодорхойлуулах,
 - 8.4.1.6 Гишүүн өөрийн хүсэлтээр өргөдөл гарган гишүүнээс татгалзах,
- 8.5 **МАЭ-ийн гишүүний үүрэг**
- 8.6 МАЭ-ийн гишүүн нь дор дурьдсан үүрэг хүлээнэ.
 - 8.6.1 МАЭ-ийн дүрэм, архитекторын ёс зүйн хэм хэмжээний стандартыг мөрдөх, холбогдох журам, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг биелүүлэх,
 - 8.6.2 МАЭ-ийн нэр хүндийг дээдлэн эв нэгдлийг эрхэмлэн хамгаалах,

- 8.6.3 МАЭ-ээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхитэй оролцох,
 - 8.6.4 МАЭ-ийн санхүүгийн чадавхыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулах,
 - 8.6.5 МАЭ-ийн гишүүний татвараа тогтоосон хугацаанд төлөх,
 - 8.6.6 МАЭ-ийн нэр хүнд, санхүү, үйл ажиллагаанд сөрөгөөр нөлөөлсөн, бусдыг үл хүндэтгэсэн, зөрчсөн аливаа үйлдэл хийхгүй байх,
- 8.7 **Гишүүнээс хасах, чөлөөлөгдөх**
- 8.7.1 Энэ зүйлд заасан үүргээ үл биелүүлэн дүрэм журмыг удаа дараа болон ноцтой зөрчсөн улмаас МАЭ-ийн нэр хүндийг унагасан хохирол учруулсан бол гишүүнчлэлээс хасна.
- 8.8 Дараах үндэслэлээр гишүүнчлэлээс хасах ба чөлөөлнө.
- 8.8.1 Гишүүн өөрөө хүсэлтээ бичгээр гаргасан,
 - 8.8.2 Сонгогдсон болон томилогдсон албан үүрэгтээ хувийн ашиг сонирхлын зөрчлөөр хандсан,
 - 8.8.3 МАЭ-ийн эрхэм зүйлсүүдийг үл хүндэтгэсэн, гутаан доромжилсон, ёс зүйн алдаа гаргасан, хуулийн байгууллагаар шийтгэгдсэн нь тогтоогдсон,
 - 8.8.4 Гишүүний татварыг хүндэтгэх шалтгаангүйгээр 6 сараас дээш хугацаанд төлөөгүй,

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

МАЭ-ийн өмч, үнэт зүйл, санхүүжилт, хөрөнгө зарцуулалт

Есдүгээр зүйл. МАЭ-ийн өмч

- 9.1 МАЭ-нь өөрийн үйл ажиллагаагаа явуулахын үндэс болсон өмчтэй байна.
- 9.2 МАЭ-ийн өмчид дор дурьдсан зүйлс хамаарна.
 - 9.2.1 МАЭ-ийн үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой газар эзэмших эрх,
 - 9.2.2 МАЭ-ийн эргэлтийн хөрөнгө,
 - 9.2.3 МАЭ-ийн лого тэмдэг, нэр, эрхлэн гаргаж буй ном сэтгүүл, түүний эрх, МАЭ-ийн түүх, архив, кино, МАЭ-ийн оролцоотой бий болгосон хөшөө дурсгал, нэрэмжит гудамж, сан хөмрөг,
- 9.3 МАЭ-ийн өмчийг МАЭ-ийн дүрэм, журам, тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор ашиглана.
- 9.4 МАЭ-ийн өмчийг дор дурьдсан үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.
 - 9.4.1 МАЭ-ийн өмчийг өмч хувьчлалд хамруулах, хувьчлахыг,
 - 9.4.2 МАЭ-ийн өмчийг хувааж авах, хувьдаа ашиглахыг, бэлэглэхийг,
 - 9.4.3 МАЭ-ийн өмчийг барьцаалан зээл авах, зээлдүүлэхийг,
 - 9.4.4 МАЭ-ийн өмчийг ашиглан хөрөнгийн баталгаа гаргахыг,
- 9.5 МАЭ-ийн Үл хөдлөх хөрөнгийг худалдах, өөрчлөх асуудлыг зөвхөн Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Аравдугаар зүйл. МАЭ-ийн санхүүжилт, хөрөнгө зарцуулалт

- 10.1 МАЭ-ийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.
 - 10.1.1 Гишүүний татвар, гишүүн байгууллагын татвар,
 - 10.1.2 Гишүүд, гадаад дотоод иргэд, байгууллагын хандив, тусламж,
 - 10.1.3 Үл хөдлөх үндсэн хөрөнгийн ашиглалттай холбогдсон орлого,
 - 10.1.4 Мэргэжлийн давтан сургалтын төлбөрийн орлого,
 - 10.1.5 Гэрээ хэлцэл, журмын дагуу туурвисан, худалдан борлуулсан бүтээлийн үнийн дүнгийн хувь,
 - 10.1.6 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор санхүүжигдсэн хөрөнгө,
 - 10.1.7 Үйл ажиллагааны орлого,
- 10.2 МАЭ-ийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, хөрөнгийг дор дурьдсан үйл ажиллагаанд зарцуулна.

- 10.2.1 МАЭ-ийн дүрмийн зорилтыг хэрэгжүүлэх,
- 10.2.2 Их хурал, Удирдах зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 10.3 МАЭ-ийн санхүүжилт, үйл ажиллагааны орлого, хөрөнгийг дор дурьдсан үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.
 - 10.3.1 МАЭ-ийн гишүүд, сонгуульт болон удирдах ажилтны хууль бус, дүрмийн бус ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулах, нөхөхөд оролцохыг
 - 10.3.2 Ашиг хуваарилах, хувьчлахыг,
 - 10.3.3 Иргэн хуулийн этгээдэд зээлдүүлэх, баталгаа гаргахыг,
 - 10.3.4 Худалдах, хувьдаа ашиглахыг,
 - 10.3.5 МАЭ-ийн үндсэн хөрөнгийг өмч хувьчлалд хамруулахыг,
- 10.4 МАЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь гишүүдэд ил тод нээлттэй байна.
- 10.5 МАЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь Монгол Улсын хэмжээнд мөрдөж буй санхүүгийн тайлан бүртгэл, татварын холбогдолтой хууль тогтоомжид нийцсэн байна.
- 10.6 Гишүүд, сонгуульт болон томилогдсон албан тушаалтны учруулсан хохирлыг өөрөөр нь нөхөн төлүүлэх бөгөөд шаардлагатай бол шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Арваннэгдүгээр зүйл. Гишүүн, гишүүн байгууллагын татвар

- 11.1 МАЭ-ийн гишүүний, гишүүн байгууллагын татварын хэмжээ:
 - 11.1.1 Гишүүний татвар /сарын/ 10 000 төгрөг /Арван мянган төгрөг/ байх,
 - 11.1.2 Гишүүн байгууллага /жилд/ 500 000 төгрөг /таван зуун мянган төгрөг/ байх,
 - 11.1.3 Ахмад /70 наснаас дээш/ татварыг хандив хэлбэрт шилжүүлэн тооцох,

Хариуцлага

- 11.2 Дүрмийн биелэлтийг Удирдах зөвлөд, Ерөнхийлөгч, Хяналтын зөвлөлийн гишүүд хянана.
- 11.3 Гишүүн болон удирдах ажилтнууд дор дурьдсан нөхцөлд асуудлыг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
 - 11.3.1 Байгууллагын өмч хөрөнгө, санхүүгийн чадавхид ноцтой хохирол учруулсан,
 - 11.3.2 Ёс суртахууны бусармаг үйлдэл гаргасан, бусдын өмч хөрөнгө, эрхэнд халдсан,

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Арванхоёрдугаар зүйл. МАЭ-ийг өөрчлөн байгуулах, татан буулгах.

- 12.1 МАЭ-ийн дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах шаардлагагүй, шинэ өөр зорилт дэвшүүлэн, өөрчлөн байгуулахаар татан буулгах буюу өөрчлөн байгуулах нөхцөлд Удирдах зөвлөлөөс бүх гишүүдийн дунд санал асуулга явуулж, санал асуулгын дүнг Их хуралд танилцуулна. Татан буулгах буюу өөрчлөн байгуулах асуудлыг МАЭ-ийн Их Хурлаар хэлэлцэн бүх гишүүдийн 75 -аас дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.

_____ оОо _____